



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН
САНГИЙН ЗАХИРАЛ П.ЧАНДМАНЬ
ТАНАА

2017.03.15 № 3/444
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3, 15 дугаар зүйлийн 15.1.1, 15.1.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Зээлийн батлан даалтын сангийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээний, өмчийн өөрчлөлтийн тайлан болон холбогдох тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаархи мэдээлэл

Зээлийн батлан даалтын сангийн удирдлага нь тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС), Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (НББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэг хариуцлага хүлээнэ.

Зээлийн батлан даалтын сангийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан нь үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журам нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Зээлийн батлан даалтын сангийн санхүүгийн тайлан, түүний тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, программ хангамж, дотоод хяналтын систем, гол хууль тогтоомжуудын мөрдөлт, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан болно.

Аудитаар дараах зөрчил илэрсэн нь санхүүгийн тайланд Хязгаарлалттай санал дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

1. Зээлийн батлан даалтын сангийн тухай хуулийн 11.2-д "Сангийн үйл ажиллагаанаас үүсэх эрсдлийг Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас давхар батлан даахтай холбогдсон журмыг Засгийн газар батална" гэсэн заалтыг

хэрэгжүүлээгүйгээс 2016 оны эцэст нийт 439 зээлдэгчийн 91,506.3 сая төгрөгийн зээлийн үлдэгдэлд 37,752.2 сая төгрөгийн батлан даалт гаргаснаас хугацаа хэтэрсэн 55 зээлдэгчийн 2,781.1 сая төгрөгийн хэвийн бус зээлийн үлдэгдэлд гаргасан 1,286.5 сая төгрөгийн чанаргүй батлан даалтын үлдэгдлээр үүрэг хүлээх эрсдэлтэй байна.

2. Тус сангийн 2016 оны Батлан даах үйл ажиллагааны тайланд нийт батлан даахаар шийдвэрлэгдсэн зээлдэгчдийн эрхэлдэг үйл ажиллагааны салбараар нь нэгтгэж үзэхэд Аялал жуулчлалын 1, Боловсролын 1, Боловсруулах үйлдвэр 2, Үйлдвэрлэл 3, Үйлчилгээ 13, Хөдөө аж ахуй 6, Худалдааны 10 байгууллага байгаа нь Зээлийн батлан даалтын сангийн тухай хуулийн 9.1.1-д "Банк, санхүүгийн байгууллагаас зээл авахыг хүссэн боловч зээлийн барьцаа хөрөнгө нь хүрэлцэхгүй байгаа жижиг, дунд үйлдвэр эрхлэгчид зээлийн 60 хүртэлх хувьд батлан даалт гаргах" гэсэн заалтыг зөрчсөн байна.
3. Голомт банкинд хугацаатай хадгаламжаар хадгалагдаж байсан эрсдлийн сангийн 200,000.0 мянган төгрөгийн хөрөнгийг Төрийн банкин дахь ажлын албаны хэрэгцээний ердийн харилцах дансанд 2016 оны 5 дугаар сарын 24-нөөс 8 дугаар сарын 24-ний өдөр хүртэл байршуулсан. Дээрх хугацаанд эрсдлийн сангийн хөрөнгө 200,000.0 мянган төгрөгийг хадгаламжийн дансанд байршуулаагүйгээс 4,786.8 мянган төгрөгийн хүүгийн орлого олох боломжийг алдсан нь Санхүүгийн Зохицуулах Хорооны 2012 оны 344-р тогтоолоор баталсан "Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих" журмын 2.1.12-т "Эрсдлийн санг тайлант хугацааны эцэс дэх цэвэр орлогоос түүний 50-иас доошгүй хувиар байгуулна. Сангийн хөрөнгийг банкинд хадгаламж хэлбэрээр байршуулах бөгөөд үйл ажиллагаанд зарцуулахыг хориглоно" гэснийг зөрчсөн байна.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Дээрх алдаа зөрчлийг эс тооцвол Зээлийн батлан даалтын сангийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон санхүүгийн тайлангийн тодруулгуудыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, НББОУС, СТОУС, түүнд нийцүүлж Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

В. М.

Ц.НАРАНЧИМЭГ



“ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САН” 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:**

САГ-ын Тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663
Цахим хаяг:

Аудитын менежер: Я.Самбууням
Утас: 260512
Цахим хаяг:

Аудитор: Н.Золзаяа
Утас: 261885
Цахим хаяг:

ТАБ-ын хаяг: Үндэсний аудитын
газар

Байршил: Чингэлтэй дүүрэг

Цахим хуудас: www.audit.mn

2017 оны 3 дугаар сар 12

Аудитын тайлан

Хавсралт 1: Дуусвар тайлан

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: МЗ-ийн хариу

Хавсралт 5: Аудит хийсэн санхүү, төсвийн
гүйцэтгэлийн тайлан, тодруулга

Хавсралт 6: Асуудлын бүртгэл

Хавсралт 7: Үйлчлүүлэгчийн албан бичиг,
санхүүгийн тайлан, тодруулга

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Материаллаг байдал
6. Дотоод хяналт
7. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
8. Шилэн дансны мэдээлэл
9. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
10. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
11. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
12. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
13. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
14. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
15. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
16. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
17. Тайлбар захидал
18. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.8, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.2 дахь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.5 дугаар зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд “Зээлийн батлан даалтын сан”-гийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд /САГ-2017/5/СТА-ЗГТС / аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

“Зээлийн батлан даалтын сан”-гийн 2016 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /НББОУС/, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/ түүнд нийцүүлэн гаргасан төрийн бус байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Сангийн удирдлага санхүүгийн тайлангаа НББОУС, СТОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын баталсан холбогдох журмууд, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, НББОУС, СТОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

“Зээлийн батлан даалтын сан”-гийн 2016 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2017 оны 2 дугаар сарын 23-наас 2017 оны 3 дугаар сарын 10-ны хооронд хийхээр төлөвлөн “Ди Эй Би Жи Аудит” ХХК-ийн аудитор Н.Дэлгэрмаа хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

“Зээлийн батлан даалтын сан”-ийн 2016 оны санхүүгийн тайланг 2017 оны 3 дүгээр сарын 03-нд “Ди Эй Би Жи Аудит” ХХК-д ирүүлсэн байна.

“Ди Эй Би Жи Аудит” ХХК аудитыг 2017 оны 3 дүгээр сарын 03-наас 2017 оны 3 дугаар сарын 10-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2017 оны 3 дугаар сарын 15-нд “Зээлийн батлан даалтын сан”-д хүргүүлнэ.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

“Зээлийн батлан даалтын сан”-ийн удирдлага нь Монгол улсын “Төсвийн тухай”, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай”, “Зээлийн батлан даалтын сангийн тухай” “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд тухайн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой “Сангийн батлан даалтын үйл ажиллагааны бодлого”, “Зээлийн батлан даалтын сангийн эрсдлийн удирдлагын бодлого”-ыг шинээр, “Батлан даалтаар хүлээсэн үүрэг гүйцэтгэх журам”, “Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-ыг шинэчлэн боловсруулж Удирдах зөвлөлөөр батлуулан хэрэгжүүлсэн.

Санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөх “Нягтлан бодох бүртгэлийн тухай”-д хууль 2016 оны 1 дугаар сарын 1-ний өдрөөс өөрчлөлт орж түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт орсон

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

“Зээлийн батлан даалтын сан”-гийн гол зорилго нь “Барьцаа хөрөнгийн дутагдалтай жижиг, дунд үйлдвэр эрхлэгчийн үйл ажиллагаанд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, сангийн үйл ажиллагааг оновчтой, үр ашигтай явуулах”-д оршино. Үйл ажиллагааны зорилтоо биелүүлэхэд дараах хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

1. Монгол Улсын Зээлийн батлан даалтын сангийн тухай хуулийн 9.1.1-д “Банк, санхүүгийн байгууллагаас зээл авахыг хүссэн боловч зээлийн барьцаа хөрөнгө нь хүрэлцэхгүй байгаа жижиг, дунд үйлдвэр эрхлэгчид зээлийн 60 хүртэлх хувьд батлан даалт гаргах”, 9.1.2-т “Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5.1-д заасны дагуу жижиг, дунд үйлдвэр эрхлэгчээс гаргасан хаалттай өрийн бичгээс банк, санхүүгийн байгууллага худалдаж авсан бол уг худалдаж авсан өрийн бичигт батлан даалт гаргах”
2. Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйл 14.2.2-т “улсын төсвөөс олгосон хөрөнгийг Төсвийн тухай хуульд заасны дагуу зарцуулж, тайлагнах” гэж тус байгууллагын үйл ажиллагааны зорилтыг тодорхойлсон байна.

“Зээлийн батлан даалтын сан”-гийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, НББОУС, СТОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар “Зээлийн батлан даалтын сан”-гийн 2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс сангийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд нягтлан бодох бүртгэлийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 45-г гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж, захирлын 2016 оны 113 дугаар тушаалаар батлуулан мөрдөж байна.

Сангийн нягтлан бодох бүртгэлийг “Апекс” санхүүгийн програмаар хөтөлж, санхүүгийн тайланг гаргасан байна.

Иймд компьютерийн системийн үйл ажиллагааны нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Материаллаг байдал:

Материаллаг байдлын түвшинг төлөвлөлтийн шатанд тайлант оны батлагдсан төсвийн өөрийн үйл ажиллагааны орлогоос 0.2 хувиар 2,156.1 мянган төгрөгөөр тогтоосон. Гүйцэтгэлийн шатанд тайлант өөрийн үйл ажиллагааны орлогын гүйцэтгэлийн дүнг материаллагийн түвшинг тогтоох суурь болгон сонгож, 0.2 хувиар тооцон материаллагийн түвшинг 2,330.9 мянган төгрөг гэж тогтоосон.

Агуулга шинж чанарын хувьд балансын гадуур бүртгэгддэг хугацаа хэтэрсэн, хэвийн бус зээлийн дүнд ногдох батлан даалтын хэмжээ, түүнээс үүрэг гүйцэтгэхээр нэхэмжлэгдэж байгаа батлан даалтын дүнд эрсдэл байж болох юм гэж материаллаг байдлын түвшинг тусад нь тогтоон хянасан. /ТАБ-СТА-В-1/

/мян.төг/

Данс	Материаллаг байдал	
	Төлөвлөлтийн шатанд	Жилийн эцсийн аудитад
Өөрийн орлого	2,156.1	2,330.9

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг нь үнэлсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Тус байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үед ҮР НӨЛӨӨТЭЙ гэж тооцсон ба дахин хянахад бүртгэлээр тавих дотоод хяналтын үйл ажиллагаа ДУНД байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

2016 оны санхүүгийн үйл ажиллагааны төсвийг удирдах зөвлөлийн 2015 оны 12 сарын 15-ны өдрийн 16-р тогтоолоор 1,078,040.1 мянган төгрөгийн орлоготой, 1,016,148.5 мянган төгрөгийн зардалтай ажиллахаар баталсан байна. Сангийн хяналтын зөвлөлөөс батлагдсан төсвийн гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

2016 онд 1,165,475.1 мянган төгрөгийн өөрийн орлоготой, 865,617.5 мянган төгрөгийн зардал гаргаж 299,857.6 мянган төгрөгийн хэмнэлттэй ажилласан байна.

Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хууль 2014 оны 7 дугаар сарын 1-ны өдөр батлагдаж, 2015 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж байна. Энэ хуулийн зорилт нь улс, орон нутгийн төсөв, улсын болон орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагааг ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих, мэдээллийн тогтолцоог бүрдүүлэхэд оршино.

Тус байгууллага нь шилэн дансны мэдээллийг 9 хавсралтын дагуу мэдээлдэг. 2016 оны батлагдсан төсөв, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа шивж оруулсан. Таван сая төгрөгөөс дээш орлогын 3,694,347.9 мянган төгрөг, зарлагын 2,266,069.5 мянган төгрөгийн гүйлгээний дэлгэрэнгүй мэдээллийг оруулсан байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 15 уламжлалт эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 45 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Тогтоосон эрсдлүүдээс дараах эрсдлүүдийг гол гэж үзэн нарийвчлан шалгасан:

- Өөрийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан байх
- Банкин дахь харилцах дансдын хүүгийн орлогыг аккрузель сууриар бүртгэж, тайлагнаагүй байх, гэрээтэй зөрүүтэй байх
- Хязгаарлалттай сангуудаас зориулалт бусаар зарцуулсан байх
- Авлага, өглөгийн тооцоог нийлж баталгаажуулаагүй байх
- Өөрийн үйл ажиллагааны орлогыг батлагдсан төсвийн дагуу зарцуулж, хянаагүй байх

Үр дагаврыг тодорхойлж чадвал: Тайлант онд тус байгууллагын хувьд дараах материаллаг хэмжээний ажил гүйлгээ гарсан байна.

Сангийн хязгаарлалттай цэвэр хөрөнгийг УЗ-ийн 2013 оны 9 дүгээр тогтоолоор батлагдсан ЗБДС-ийн хөрөнгө, мөнгөн хөрөнгийг удирдах, байршуулах журмын 3.2 "Сангийн хөрөнгийг сонгон байршуулахыг УЗ шийдвэрлэнэ" гэсний дагуу банкинд байршуулна. УЗ-ийн 2016 оны 5-р тогтоолоор сангийн хөрөнгийг үр ашигтай, эрсдлийг тооцсон хэлбэрээр арилжааны банкуудад байршуулах, гэрээ байгуулахыг Гүйцэтгэх захиралд зөвшөөрч хэрэгжүүлсэн байна. Өөрийн хөрөнгө 5,040.0 сая төгрөгийг 3 арилжааны банкны дөрвөн дансанд 1 жилийн хугацаатай хадгаламж хэлбэрээр дараах байдлаар тараан байрлуулсан байна.

- 2016 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн № 340003851404 тоот гэрээний дагуу Төрийн банкинд жилийн 16.4%-ийн 2 тэрбум төгрөгийг байршуулсан.
- 2016 оны 5 дугаар сарын 24-ны өдрөөс гэрээний дагуу Хас банкны 5001371562 тоот дансанд 13 сарын хугацаатай жилийн 17% хувийн хүүтэйгээр 1 тэрбум төгрөг хадгалуулсан.
- 2016 оны 4 дүгээр сарын 27-ны өдрөөс гэрээний дагуу Капитал банкны 2200000432 дансанд 1 тэрбум төгрөгийг жилийн 16.6%-ийн хүүтэйгээр жилийн эцэст болон хугацааны эцэст хүүг олгох нөхцөлтэй байршуулсан.
- 2016 оны 5 дугаар сарын 24-ны өдрийн № 2200000042 тоот гэрээний дагуу Капитал банкны 2200000042 дансанд 1 тэрбум төгрөгийг жилийн 17.6 хувийн хүүтэй, 13 сарын хугацаатай, хүүг сар бүр бодож олгох нөхцөлтэй байршуулсан байна.

Хүүгийн орлогыг аккрузель сууриар бүртгэн 942,605.8 мянган төгрөгийн орлоготой ажилласан байна. Төрийн банкны ердийн харилцах дансанд эрсдлийн сангийн 200,000.0 мянган төгрөгийн хөрөнгийг 3 сарын хугацаанд байршуулан хүүгийн орлого тооцож аваагүй тул өмнөх Голомт банкны хугацаатай хадгаламж дансанд тооцож байсан хувиар тооцоолоход 4,786.8 мянган төгрөгийн орлогыг дутуу төвлөрүүлсэн байна.

Тайлант онд үйлчлүүлэгчийн тооцоолсноор 300,184.0 мянган төгрөгийн цэвэр орлоготой ажиллаж, үүнээс 66.6 хувиар эрсдлийн сан байгуулсан нь СЗХ-ны 2012 оны 344-р тогтоолоор баталсан "Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих" журмын 2.1.12-т "нөөц санг тайлант хугацааны эцэс дэх цэвэр орлогоос түүний 50-иас доошгүй хувиар байгуулна" гэснийг хангаж байна. Голомт банкны Тэнгис салбарт 1 сарын хугацаатай хадгалуулсан 200.0 сая төгрөгийн хадгаламжийг 2016 оны 5 дугаар сарын 24-нд Төрийн банкин дахь ажлын албаны хэрэгцээний ердийн

харилцах дансанд 8 дугаар сарын 24 хүртэл татаж үйл ажиллагаандаа зарцуулж байсан нь дээрх заалтаар “Сангийн хөрөнгийг банкинд хадгаламж хэлбэрээр байршуулах бөгөөд үйл ажиллагаанд зарцуулахыг хориглоно” гэснийг зөрчсөн байна.

Тайлант онд харилцагч 6 банкны урт хугацаат хадгаламжийн хүүгийн орлогын авлага 160,635.3 мянган төгрөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй тайлагнасан. Дээрх авлагын тооцоонд аудитын тулган баталгаажуулах захидал явуулахад Голомт банкны тэнгис салбарын 29,702.0 мянган төгрөгийн баталгаажуулалт ирээгүй.

Тайлант онд нийт 865,617.5 мянган төгрөгийн зардалтай ажилласнаас 543,608.3 мянган төгрөг буюу 62.8 хувь цалин нийгмийн даатгалын шимтгэл, 151,726.2 мянган төгрөг буюу 17.5 хувь түрээсийн зардал, 39,716.5 мянган төгрөг буюу 4.5 хувь элэгдлийн зардал тайлагнасан байна. Програмын түрээсийн зардал 13,200.0 мянган төгрөг, удирдлагын зардал 3,479.6 мянган төгрөг, хангамжийн материалын зардал 955.3 мянган төгрөг нийт 17,364.9 мянган төгрөгийг тодотгол хийгээгүй, бүлэг хооронд шилжүүлэн зарцуулсан байна.

Энэ нь тухайн дансуудын хувьд оршин байх, үнэлгээ, эрх үүрэг, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг бүрэн хангаагүй байна.

Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

Тус байгууллагын 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний хязгаарлалттай нөөц хөрөнгө, эрсдлийн сангийн хөрөнгө, мөнгөн хөрөнгө, шилэн дансны тайлан, хүүгийн орлого, цалин, нийгмийн даатгалын шимтгэл, түрээс, үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь тус байгууллагын нийт орлогын 80.8 хувь, нийт зардлын 84.8 хувь, нийт хөрөнгийн 95.1 хувийг тус тус эзэлж байна.

Дараах хууль, дүрэм, журмын шалгуур үзүүлэлтүүдийг санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдлөг болгож байна.

- а) Зээлийн батлан даалтын сангийн тухай хуулийн 9.3 “сангийн хөрөнгийг банкинд хадгаламж, харилцах хэлбэрээр болон Засгийн газрын өрийн бичиг, Санхүүгийн зохицуулах хорооноос зөвшөөрсөн бусад хэлбэрээр байршуулж болно”
- б) УЗ-ийн 2013 оны 09-р тогтоолоор баталсан “Зээлийн батлан даалтын сангийн хөрөнгө, мөнгийг удирдах, байршуулах” журам
 - 3.3 сангийн хөрөнгийг банкны харилцах, хадгаламж хэлбэрээр Монгол банкны тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг сүүлийн 2 жилийн хугацаанд тогтмол хангасан 3-аас доошгүй банкинд байршуулна
 - 4.2 сан үйл ажиллагаатай холбоотой гарах зардлыг УЗ-ийн баталсан төсвийн хүрээнд зарцуулна
 - 4.3 сан нь болзошгүй эрсдлээс хамгаалах зорилгоор эрсдлийн сан байгуулж болно.

- с) УЗ-ийн 2013 оны 09-р тогтоолоор батлагдсан “Батлан даалтын төрөл, хэмжээ, хугацаа, хураамж, шимтгэл, бусад нөхцлийн тухай” журмын
- 3.1 батлан даалт гаргуулсан эсэхээс үл хамааран үйлчилгээний хураамж 10000 төгрөгийг санд урьдчилан төлнө.
 - 3.2 батлан даалтын шимтгэлийг батлан даах хугацаанаас хамаарч дараах хувиар тооцож авна
 - 3.3 зээлдэгчид олгох зээлээс батлан даалтын шимтгэлийг суутгаж сангийн дансанд шилжүүлнэ.
- д) СЗХ-ны 2016 оны 238-р тогтоолоор батлагдсан “зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааны шалгуур үзүүлэлт, хяналт тавих” журмын
- 2.1.2 нэг зээлдэгчид гаргах зээлийн батлан даалтын хэмжээ нь банк, санхүүгийн байгууллагаас авах тухайн зээлийн 60 хүртэлх хувь буюу сангийн өөрийн хөрөнгийн 10 хувиас хэтрэхгүй байна
 - 2.1.3 гаргасан зээлийн батлан даалтын нийт хэмжээ нь өөрийн хөрөнгийг 10 дахин нэмэгдүүлснээс хэтрэхгүй байх
 - 2.1.11 эрсдлийн санг тайлант хугацааны эцэс дэх цэвэр орлогоос түүний 50-иас доошгүй хувиар байгуулна. Эрсдлийн сангийн хөрөнгийг банкинд хадгаламж хэлбэрээр байршуулах бөгөөд үйл ажиллагаанд зарцуулахыг хориглоно.

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг хэмжээний дараах алдаа илэрсэн байна. Үүнд:

1. Эрсдлийн сангийн хөрөнгө:

Эрсдлийн сангийн хөрөнгийг оны эхэнд Голомт банкинд хадгаламж хэлбэрээр байршиж байсныг 2016 оны 2 дугаар сарын 23-ны өдрөөс Голомт банкны 2 салбарт 1 сар, 3 сарын хугацаатай хадгаламжаар хувааж байршуулсан. Голомт банкны Тэнгис салбарт 1 сарын хугацаатай хадгалуулсан 200.0 сая төгрөгийн хадгаламжийг 2016 оны 5 дугаар сарын 24-ны өдөр Төрийн банкин дахь ажлын албаны хэрэгцээний ердийн харилцах дансанд 2016 оны 8 дугаар сарын 24-ний өдөр хүртэл татаж үйл ажиллагаандаа зарцуулж байсан нь СЗХ-ны 2016 оны 238-р тогтоолоор баталсан "Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих" журмын 2.1.11-т "нөөц санг тайлант хугацааны эцэс дэх цэвэр орлогоос түүний 50-иас доошгүй хувиар байгуулна. Сангийн хөрөнгийг банкинд хадгаламж хэлбэрээр байршуулах бөгөөд үйл ажиллагаанд зарцуулахыг хориглоно" гэснийг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Эрсдлийн сангийн хөрөнгийг СЗХ-ны 2016 оны 238 тогтоолын дагуу зохих удирдах байгууллагууд хянах, жилийн хугацаанд сонгосон банкинд тогтвортой хадгалах, хадгаламжийн хугацааг журамд болон бусад хэлбэрээр тогтоон өгч мөрдүүлэх зөвлөмж өгсөн боловч Үйлчлүүлэгчийн удирдлага “Эрсдлийн сангийн хөрөнгийг ЗБДС-ийн 9.3, СЗХ-ны 2012 оны 344-р тогтоолоор батлагдсан журмын дагуу Төрийн банкинд 2016.05.24-нд байршуулсан. Сангийн үйл ажиллагаанд зарцуулаагүй болно” гэсэн тайлбарыг ирүүлж хүлээн зөвшөөрөөгүй. СЗХ-ны 2012 оны 344 тогтоолын 2.1.12, 2016 ойн 238 тогтоолын 2.1.11 заалтууд

ижил утгатай бөгөөд шинэчилсэн журам дээр “нөөц сан” гэсэн нэр томъёо оруулсан байгааг СЗХ-оос тодруулга авах
Аудитын зүгээс албан шаардлага өгөхөөр төлөвлөсөн болно

2. Төсвийн гүйцэтгэл:

УЗ-ийн 2015 оны 16-р тогтоолоор баталсан 2016 оны төсөвт тусгагдаагүй програмын түрээсийн зардал 13,200.0 мянган төгрөг, удирдлагын зардал 3,479.6 мянган төгрөг, хангамжийн материалын зардлын батлагдсан төсвөөс 955.3 мянган төгрөг нийт 17,634.9 мянган төгрөгийг хэтрүүлэн зарцуулсан нь УЗ-ийн 2014 оны 09 тогтоолоор батлагдсан Сангийн дүрмийн 7.1 "сангийн хөрөнгийг батлагдсан төсвөөс хэтрүүлэх, өөр зориулалтаар ашиглах, зарцуулахыг хориглоно" гэснийг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Сангийн дүрмийн 2.11.9. Гүйцэтгэх захирлын гэрээнд заасны дагуу батлагдсан төсөв, өмч хөрөнгийг үр ашигтай хэмнэлттэй зарцуулах, төлөвлөгөөг бодитой төлөвлөж, батлуулахад анхаарах зөвлөмж өгснийг хүлээн авч төсвийг нийт дүнгээр хэтрүүлээгүй бүлэг хооронд шилжүүлэн зарцуулсан талаар тайлбар ирүүлсэн

3. Хүүгийн орлогын авлага:

Харилцагч 6 банкны урт хугацаат хадгаламжийн хүүгийн орлогын авлага 160,635.3 мянган төгрөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй тайлагнасан нь НББ-ийн тухай хуулийн 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэснийг хэрэгжүүлээгүй

Шийдвэрлэсэн нь: НББ-ийн тухай хуулийн 20.2.3 "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэснийг баримтлан бүртгэл тооцоогоо бүрэн хөтөлж, баримтжуулж байх зөвлөмж өгч, харилцагч банкуудад тулган баталгаажуулах захидал явуулахад Голомт банкны 2 дансны 29,702.0 мянган төгрөгийн баталгаажуулалт ирээгүй.

4. Хүүгийн орлого:

2016 оны 5 дугаар сарын 24-ний өдрөөс 8 дугаар сарын 24-ний өдрийг хүртэл хугацаанд эрсдлийн сангийн хөрөнгө 200,000.0 мянган төгрөгийг Төрийн банкны 341201146201 тоот ердийн харилцах дансанд байршуулан сангийн үйл ажиллагаанд зарцуулж, тухайн хугацаанд тооцогдох хүүгийн орлогыг бүртгэж тайлагнаагүй нь НББ-ийн тухай хуулийн 5.1 Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална: "5.1.4.үнэн зөв байх", Төсвийн тухай хуулийн 6.3 Төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ: "6.3.1.төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр

төлбөрийн гүйлгээг бууруулах бичилт хийхгүйгээр нийт дүнгээр нь төлөвлөж, тайлагнах" гэснийг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн банкинд эрсдлийн сангийн 200,000.0 мянган төгрөгийн хөрөнгийг 3 сарын хугацаанд байршуулан хүүгийн орлого тооцож аваагүй тул өмнөх Голомт банкны хугацаатай хадгаламж дансанд тооцож байсан хувиар тооцоолон 4,786.8 мянган төгрөгийн орлогыг дутуу төвлөрүүлсэн талаар зөвлөмж өгснийг хүлээн зөвшөөрөөгүй тул аудитын албан шаардлага өгөхөөр төлөвлөсөн.

Материаллаг бус дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

Дараах үйл ажиллагаатай холбоотой агуулга шинж чанарын хувьд материаллаг алдаа илэрхийлж болох асуудлуудыг аудитын асуудлын бүртгэлээр үйлчлүүлэгчийн удирдлагуудад танилцуулан, ирүүлсэн тайлбар, баримтуудыг хүлээн авч хавсаргалаа.

1. Хуулийн хэрэгжилт:

Зээлийн батлан даалтын сангийн тухай хуулийн 11.2-д "Сангийн үйл ажиллагаанаас үүсэх эрсдэлийг Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас давхар батлан даахтай холбогдсон журмыг Засгийн газар батална" гэсэн хуулийн заалт үүсгэн байгуулснаас хойш хэрэгжээгүй байна. Тайлант оны эцэст банкуудаас 16 зээлдэгчийн 961,511.6 мянган төгрөгийн үүрэг гүйцэтгүүлэх нэхэмжлэх ирсэн байна. Мөн батлан даалтын үлдэгдлийн тайлангаар оны эцэст 55 зээлдэгчийн 1,286,496.0 мянган төгрөгийн чанаргүй батлан даалтын үлдэгдэлтэй байгаа нь батлан даалтын үүрэг гүйцэтгэж болзошгүй эрсдэл үүссэн байна

Шийдвэрлэсэн нь: Сангийн үйл ажиллагаа нь барьцаа хөрөнгийн дутагдалтай жижиг, дунд үйлдвэр эрхлэгчийн үйл ажиллагаанд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, сангийн үйл ажиллагааг оновчтой, үр ашигтай явуулах үндсэн зорилгоо биелүүлэхэд мөрдөж байгаа хууль, дүрэм, журмуудын хэрэгжилт зөв зохистой байгаа эсэхийг ҮАГ-аас нийцлийн аудит хийж, дүгнэлт гаргах санал оруулах

2. Санхүүгийн тайлагнал:

Аудит хийлгэхээр ирүүлсэн Санхүүгийн тайлангийн СТ-3 Цэвэр хөрөнгийн өөрчлөлтийн тайланд Хязгаарлалттай нөөц сангийн эхний болон эцсийн үлдэгдэл 5,040,000.0 мянган төгрөг тайлагнаагүй, СТ-2 Үр дүнгийн тайлангийн нийт орлогын дүн тодруулгын дүнтэй 99,671.5 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байгаа нь НББ-ийн тухай хуулийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэсэнд нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тус сангийн нягтлан бодох бүртгэлийг Алект програмаар бүртгэн, тайлагнадаг бөгөөд өмнөх онд гарч байсан алдаа дутагдлууд засагдаагүйгээс дээрх алдаа гарсан байна. СС-ын

2005 оны 385-р тушаалаар батлагдсан Төрийн бус байгууллагын Санхүүгийн тайлан, түүний тодруулгыг бэлтгэх зааврын дагуу тайлан, тодруулгыг залруулан тайлагнаж ирүүлсэн боловч засуулахгүй бол энэ мэт алдаа байнга гаргах тул анхаарах шаардлагатай

Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Голомт банкны Тэнгис салбарт 1 сарын хугацаатай хадгаламж хэлбэрээр хадгалуулсан 200.0 сая төгрөгийн Эрсдлийн сангийн хөрөнгийг 2016 оны 5 дугаар сарын 24-нийн өдөр Төрийн банкин дахь ажлын албаны хэрэгцээний ердийн харилцах дансанд 8 дугаар сарын 24-ний өдрийг хүртэл татаж үйл ажиллагаандаа зарцуулж байсан нь СЗХ-ны 2012 оны 344-р тогтоолоор баталсан "Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих" журмын 2.1.12-т "эрсдлийн санг тайлант хугацааны эцэс дэх цэвэр орлогоос түүний 50-иас доошгүй хувиар байгуулна. Сангийн хөрөнгийг банкинд хадгаламж хэлбэрээр байршуулах бөгөөд үйл ажиллагаанд зарцуулахыг хориглоно" гэснийг хэрэгжүүлээгүй байна. Дээрх 200.0 сая төгрөгийг өмнөх хугацаатай хадгаламжийн дансанд байршуулж байсан үеийн хүүгийн орлого тооцох хувиар тооцож 4,786.8 мянган төгрөгийн орлогыг дутуу төвлөрүүлснийг залруулан бүртгэхийг зөвлөхөд үйлчлүүлэгчийн удирдлагууд хүлээн зөвшөөрөөгүй болно. Иймд дээрх зөрчлийг арилгах аудитын албан шаардлагын төсөл хянуулахаар УАГ-т хүргүүлж байна.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

ЗБДС-ийн батлан даах үйл ажиллагаа балансын гадуур бүртгэгдэж, Санхүүгийн зохицуулах хороо, сангийн Удирдах зөвлөл, Хяналтын зөвлөлүүд өөрсдийн үүрэг хариуцлагын дагуу хянаж, зөвлөмж өгөх, шийдвэр гаргах үйл ажиллагаа явагддаг.

Тайлант оны эцэст 439 зээлдэгчийн 91,506.3 сая төгрөгийн зээлийн үлдэгдэлд 37,752.2 сая төгрөгийн батлан даалт гаргаснаас хугацаа хэтэрсэн 55 зээлдэгчийн 2,781.1 сая төгрөгийн зээлийн үлдэгдэлд гаргасан 1,286.5 сая төгрөгийн чанаргүй батлан даалтын үлдэгдэл байна.

2016 онд шийдвэрлэсэн 36 зээлдэгчийн батлан даалтын мэдээнээс эрхэлдэг үйл ажиллагааны салбараар нь нэгтгэж харахад Аялал жуулчлалын 1, Боловсролын 1, Боловсруулах үйлдвэр 2, Үйлдвэрлэл 3, Үйлчилгээ 13, Хөдөө аж ахуй 6, Худалдааны 10 байгууллага байна. Энэ нь Монгол Улсын Зээлийн батлан даалтын сангийн тухай хуулийн 9.1.1-д "Банк, санхүүгийн байгууллагаас зээл авахыг хүссэн боловч зээлийн барьцаа хөрөнгө нь хүрэлцэхгүй байгаа жижиг, дунд үйлдвэр эрхлэгчид зээлийн 60 хүртэлх хувьд батлан даалт гаргах" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй нь тус сангийн дүрмээр хүлээсэн үндсэн зорилгод нийцээгүй.

Мөн Зээлийн батлан даалтын сангийн тухай хуулийн 11.2-д "Сангийн үйл ажиллагаанаас үүсэх эрсдэлийг Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас давхар батлан даахтай холбогдсон журмыг Засгийн газар батална" гэсэн хуулийн заалт үүсгэн байгуулснаас хойш хэрэгжээгүй байгаа нь батлан даах үйл ажиллагаанд үүсэх эрсдлийг урьдчилан хянах, удирдах үйл ажиллагаанд эрсдэл үүссэн байна.

Тайлант хугацааны эцэст харилцагч банкуудаас 16 зээлдэгчийн 2,323.0 сая төгрөгийн зээлийн үлдэгдэлд 961.5 сая төгрөгийн батлан даалтын үүрэг

гүйцэтгүүлэх нэхэмжлэх ирж, 1 зээлдэгчийн зээл төлөгдсөн учир 60.2 сая төгрөгийн нэхэмжлэх үүрэг гүйцэтгэхгүй, 1 зээлдэгчийн 18.5 сая төгрөгийн батлан даалтын үүрэг гүйцэтгэсэн байна. Үүрэг гүйцэтгэх нэхэмжлэхийн эцсийн дүнгээр 882.8 сая төгрөг байгаа нь эрсдлийн санд байршуулсан хөрөнгөөс 132.9 сая төгрөгөөр илүү байна.

Аудитын багийн зүгээс “Сангийн үйл ажиллагаа нь барьцаа хөрөнгийн дутагдалтай жижиг, дунд үйлдвэр эрхлэгчийн үйл ажиллагаанд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, сангийн үйл ажиллагааг оновчтой, үр ашигтай явуулах” үндсэн зорилгоо биелүүлэхэд мөрдөж байгаа хууль, дүрэм, журмуудын хэрэгжилт зөв зохистой байгаа эсэхийг УАГ-аас нийцлийн аудит хийж, зөвлөмж, дүгнэлт гаргах санал оруулж байна.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Тус сангийн 2016 оны нягтлан бодох бүртгэл хөтлөх, тайлагнах үйл ажиллагаа нь СТОУС, НББОУС, НББ-ийн тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан дүрэм, журам, зааврыг зөрчөөгүй үнэн зөв илэрхийлэгдсэн боловч сангийн үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хууль, дүрэм, журмуудын хоорондын нийцэл, хэрэгжилтийг хянан зөвлөмж, дүгнэлт гаргах шаардлагатай байна.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

“Зээлийн батлан даалтын эрсдлийн сан”-гийн 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 5,522,728.6 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн. Үүнээс Аудитын асуудлын бүртгэлд тэмдэглэгдсэн 2 алдаа 5,139,671.5 мянган төгрөгийг хүлээн зөвшөөрч аудитын явцад залруулж, 1 асуудал 4,786.8 мянган төгрөгийг хүлээн зөвшөөрөөгүй залруулаагүй тайлагнасан. Мөнгөн дүнгээр залруулагдахгүй боловч үйл ажиллагааны үр дүнд засаж сайжруулахаар хүлээн зөвшөөрсөн 3 асуудал 378,270.2 мянган төгрөгийн зөрчил байна

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

“Зээлийн батлан даалтын эрсдлийн сан”-ийн 2015 оны санхүүгийн тайланд “Ди Эй Би Жи Аудит” ХХК-ийн хийсэн аудитаар 9 асуудлаар зөвлөмж өгснийг тайлант хугацаанд 5 асуудлыг бүрэн хэрэгжүүлж, 1 асуудлыг хэрэгжүүлж эхэлсэн, 3 асуудал хэрэгжээгүй байгаа нь 61.1 хувь биелүүлсэн гэж дүгнэсэн.

- 1) Зээлийн батлан даалтын сангийн тухай хуулийн 11.2-д "Сангийн үйл ажиллагаанаас үүсэх эрсдэлийг Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас давхар батлан даахтай холбогдсон журмыг Засгийн газар батална" гэсэн хуулийн заалт үүсгэн байгуулснаас хойш хэрэгжээгүй байна.
- 2) Тайлант хугацаанд төлөвлөгөөг бодитой төлөвлөж, батлуулан мөрдөх талаар өгсөн зөвлөмж бүрэн хэрэгжээгүй байна.
- 3) Аудит хийлгэхээр ирүүлсэн Санхүүгийн тайлангийн СТ-3 Цэвэр хөрөнгийн өөрчлөлтийн тайланд Хязгаарлалттай нөөц сангийн эхний болон эцсийн үлдэгдэл 5,040,000.0 мянган төгрөг тайлагнаагүй, СТ-2 Үр дүнгийн тайлангийн нийт орлогын дүн тодруулгын дүнтэй 99,671.5 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байгаа нь санхүүгийн програмын үйл ажиллагааг засаж сайжруулах, стандарт, журам, зарчимд нийцүүлэх талаар өгсөн зөвлөмж хэрэгжээгүй байна.

Тайлбар захидал

АОУСтандарт 580-ын дагуу үйлчлүүлэгчийн удирдлагаас бид энэхүү санхүүгийн тайланг стандарт, хууль журамд нийцүүлэн бэлтгэсэн талаарх хариуцлагыг хүлээх болон гаргаж өгсөн баримт нотолгоонууд бүрэн гүйцэд үнэн зөв гэдгийг баталсан удирдлагын хариуцлагын захидлыг 2017.03.13-ны өдөр албан бичгээр гаргуулан авч хавсаргалаа.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Тайлбар

1. Зээлийн батлан даалтын сангийн тухай хуулийн 11.2-д "Сангийн үйл ажиллагаанаас үүсэх эрсдэлийг Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас давхар батлан даахтай холбогдсон журмыг Засгийн газар батална" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүйгээс 2016 оны эцэст нийт 439 зээлдэгчийн 91,506.3 сая төгрөгийн зээлийн үлдэгдэлд 37,752.2 сая төгрөгийн батлан даалт гаргаснаас хугацаа хэтэрсэн 55 зээлдэгчийн 2,781.1 сая төгрөгийн хэвийн бус зээлийн үлдэгдэлд гаргасан 1,286.5 сая төгрөгийн чанаргүй батлан даалтын үлдэгдлээр үүрэг хүлээх эрсдэлтэй байна.
2. Тус сангийн 2016 оны Батлан даах үйл ажиллагааны тайланд нийт батлан даахаар шийдвэрлэгдсэн 36 зээлдэгчдийн эрхэлдэг үйл ажиллагааны салбараар нь нэгтгэж үзэхэд Аялал жуулчлалын 1, Боловсролын 1, Боловсруулах үйлдвэр 2, Үйлдвэрлэл 3, Үйлчилгээ 13, Хөдөө аж ахуй 6, Худалдааны 10 байгууллага байгаа нь Зээлийн батлан даалтын сангийн тухай хуулийн 9.1.1-д "Банк, санхүүгийн байгууллагаас зээл авахыг хүссэн боловч зээлийн барьцаа хөрөнгө нь хүрэлцэхгүй байгаа жижиг, дунд үйлдвэр эрхлэгчид зээлийн 60 хүртэлх хувьд батлан даалт гаргах" гэсэн заалтыг зөрчсөн байна.
3. Голомт банкинд хугацаатай хадгаламжаар хадгалагдаж байсан эрсдлийн сангийн 200,000.0 мянган төгрөгийн хөрөнгийг Төрийн банкин дахь ажлын албаны хэрэгцээний ердийн харилцах дансанд 2016 оны 5 дугаар сарын 24-нөөс 8 дугаар сарын 24-ний өдөр хүртэл байршуулсан. Дээрх хугацаанд эрсдлийн сангийн хөрөнгө 200,000.0 мянган төгрөгийг хадгаламжийн дансанд байршуулаагүйгээс 4,786.8 мянган төгрөгийн хүүгийн орлого олох боломжийг алдсан нь Санхүүгийн Зохицуулах Хорооны 2012 оны 344-р тогтоолоор баталсан "Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих" журмын 2.1.12-т "эрсдлийн санг тайлант хугацааны эцэс дэх цэвэр орлогоос түүний 50-иас доошгүй хувиар байгуулна. Сангийн хөрөнгийг банкинд хадгаламж хэлбэрээр байршуулах бөгөөд үйл ажиллагаанд зарцуулахыг хориглоно" гэснийг зөрчсөн байна.

"Зээлийн батлан даалтын сан"-ийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлангийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан дээр дурьдсан зөрчлийн үзүүлж болзошгүй нөлөөллийг эс тооцвол НББОУС, СТОУС, Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу илэрхийлсэн байна.



“ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САН” 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №2 зүйлс:

Асуудал 1
Эрсдлийн сангийн хөрөнгө.....2

Асуудал 2
Төсвийн гүйцэтгэл.....3

Тэргүүлэх ач холбогдол №3 зүйлс:

Асуудал 3
Хүүгийн орлогын авлага.....4

Асуудал 4
Хүүгийн орлого.....5

Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг “Зээлийн батлан даалтын сан”-ийн удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал буюу горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулж болох зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ҮАГ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан “Зээлийн батлан даалтын сан”-ийн удирдлага болон ажилтнуудад талархал илэрхийлье.

Ажиглалт

Эрсдлийн сангийн хөрөнгийг оны эхэнд Голомт банкинд хадгаламж хэлбэрээр байршиж байсныг 2.23-наас Голомт банкны 2 салбарт 1 сар, 3 сарын хугацаатай хадгаламжаар хувааж байршуулсан. Голомт банкны Тэнгис салбарт 1 сарын хугацаатай хадгалуулсан 200.0 сая төгрөгийн хадгаламжийг 5.24-нд Төрийн банкин дахь ажлын албаны хэрэгцээний ердийн харилцах дансанд 8.24 хүртэл татаж үйл ажиллагаандаа зарцуулж байсан нь СЗХ-ны 2016 оны 238-р тогтоолоор баталсан "Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих" журмын 2.1.11-т "нөөц санг тайлант хугацааны эцэс дэх цэвэр орлогоос түүний 50-иас доошгүй хувиар байгуулна. Сангийн хөрөнгийг банкинд хадгаламж хэлбэрээр байршуулах бөгөөд үйл ажиллагаанд зарцуулахыг хориглоно" гэснийг хэрэгжүүлээгүй байна.

Эрсдэл

Дотоод хяналт, удирдах байгууллагуудаас сангийн үйл ажиллагаанд мөрдөх хууль, дүрэм, журмын хэрэгжилтэд тавих хяналтыг сулруулснаар хөрөнгө завших, зориулалт бусаар зарцуулах

Зөвлөмж

Эрсдлийн сангийн хөрөнгийг СЗХ-ны 2016 оны 238 тогтоолын дагуу зохих удирдах байгууллагууд хянах, жилийн хугацаанд сонгосон банкинд тогтвортой хадгалах, хадгаламжийн хугацааг журамд болон бусад хэлбэрээр тогтоон өгч мөрдүүлэх

Үйлчлүүлэгчийн хариу

Эрсдлийн сангийн хөрөнгийг ЗБДС-ийн 9.3, СЗХ-ны 2012 оны 344-р тогтоолоор батлагдсан журмын дагуу Төрийн банкинд 2016.05.24-нд байршуулсан. Сангийн үйл ажиллагаанд зарцуулаагүй болно.

Ажиглалт

УЗ-ийн 2015 оны 16-р тогтоолоор баталсан 2016 оны төсөвт тусгагдаагүй програмын түрээсийн зардал 13,200.0 мянган төгрөг, удирдлагын зардал 3,479.6 мянган төгрөг, хангамжийн материалын зардлын батлагдсан төсвөөс 955.3 мянган төгрөг нийт 17,634.9 мянган төгрөгийг хэтрүүлэн зарцуулсан нь УЗ-ийн 2014 оны 09 тогтоолоор батлагдсан Сангийн дүрмийн 7.1 "сангийн хөрөнгийг батлагдсан төсвөөс хэтрүүлэх, өөр зориулалтаар ашиглах, зарцуулахыг хориглоно" гэснийг хэрэгжүүлээгүй байна.

Нэгэнт худалдаж аваад ашиглаж байгаа програмд Хөрөнгө оруулалтын зардал гэж төсөв батлуулан зардал төлөвлөсөн шалтгааныг баримтаар нотлоогүй болно.

Зөвлөмж

Сангийн дүрмийн 2.11.9, Гүйцэтгэх захирлын гэрээнд заасны дагуу батлагдсан төсөв, өмч хөрөнгийг үр ашигтай хэмнэлттэй зарцуулах, төлөвлөгөөг бодитой төлөвлөж, батлуулах, зардлын зүйлийг зөв тайлагнахад анхаарах

Эрсдэл

Өмч хөрөнгийг батлагдсан төсөв, эрх үүргийн дагуу зарцуулаагүй, худалдан авалтын үйл ажиллагаанд чанарын хяналт тавиагүйгээс нэмж үргүй зардал гарах

Үйлчлүүлэгчийн хариу

УЗ-ийн 2015 оны 16-р тогтоолоор нийт төсвийг 1,016.1 сая төгрөгөөр баталж, 866.5 сая төгрөгийн гүйцэтгэлтэй ажиллаж, 149.6 сая төгрөг буюу 14.7 хувиар хэмнэж ажилласан. Батлагдсан төсвийн зардлыг бүлэг хооронд гүйлгэж зарцуулсан бөгөөд төсвийг хэтрүүлэн зарцуулаагүй болно.

Ажиглалт

Харилцагч 6 банкны урт хугацаат хадгаламжийн хүүгийн орлогын авлага 160,635.3 мянган төгрөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй тайлагнасан нь НББ-ийн тухай хуулийн 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэснийг хэрэгжүүлээгүй

Зөвлөмж

НББ-ийн тухай хуулийн 20.2.3 "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэснийг баримтлан бүртгэл тооцоогоо бүрэн хөтөлж, баримтжуулж байх
Аудитын тулган баталгаажуулах захидлуудын хариуг харилцагч банкуудаас бүрэн авч ирүүлэх

Эрсдэл

Хууль, дүрэм, журмын хэрэгжүүлээгүйгээс хөрөнгийг зориулалт бусаар зарцуулах

Үйлчлүүлэгчийн хариу

Тухайн банкны дансны гүйлгээ, үлдэгдлийн баталгаа, хадгаламжийн гэрээг үндэслэн 160.6 сая төгрөгөөр тайлагнасан бөгөөд дээрх авлагын дүн зөв болно.

Ажиглалт

2016 оны 5.24-8.24 хүртэл хугацаанд эрсдлийн сангийн хөрөнгө 200,000.0 мянган төгрөгийг Төрийн банкны 341201146201 тоот ердийн харилцах дансанд байршуулан сангийн үйл ажиллагаанд зарцуулж, тухайн хугацаанд тооцогдох хүүгийн орлогыг бүртгэж тайлагнаагүй нь НББ-ийн тухай хуулийн 5.1 Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална: "5.1.4.үнэн зөв байх", Төсвийн тухай хуулийн 6.3 Төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ: "6.3.1.төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийн гүйлгээг бууруулах бичилт хийхгүйгээр нийт дүнгээр нь төлөвлөж, тайлагнах" гэснийг хэрэгжүүлээгүй байна.

Эрсдэл

Санхүүгийн үйл ажиллагаанд холбогдох хууль, дүрэм, журмыг хэрэгжүүлээгүйгээс хөрөнгө завших

Зөвлөмж

Төрийн банкинд эрсдлийн сангийн 200,000.0 мянган төгрөгийн хөрөнгийг 3 сарын хугацаанд байршуулан хүүгийн орлого тооцож аваагүй тул өмнөх Голомт банкны хугацаатай хадгаламж дансанд тооцож байсан хувиар тооцоолон 4,786.8 мянган төгрөгийн орлогыг буруу зарцуулсан албан тушаалтнуудаар нөхөн төлүүлж байгууллагыг хохиролгүй болгох. Хүүгийн орлого, авлага дансанд залруулга хийж, тайлагнах

Үйлчлүүлэгчийн хариу

УЗ-ийн 2016 оны 11 дүгээр тогтоолоор баталсан “ Батлан даалтын гэрээгээр хүлээсэн үүрэг гүйцэтгэх журам”-д заасны дагуу эрсдлийн сангийн хөрөнгийг зээлдүүлэгчийн өмнө гэрээгээр хүлээсэн үүрэг гүйцэтгэхэд шаардагдах хөрөнгө учир эрсдлийн санг хугацаатай хадгаламж хэлбэрээр байршуулах нь болзошгүй эрсдэлд бэлэн байх боломжийг хязгаарлаж байна. Байгууллагын үйл ажиллагааны харилцах дансанд эрсдлийн хөрөнгө байршсан тул хүү тооцож авах боломжгүйгээс орлогоор тооцож бүртгээгүй болно.


АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

"ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САН"

2016 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
A.	ХӨРӨНГӨ		
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ		
	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	3,923,545,764.45	6,213,932,552.38
	Богино хугацаат хөрөнгө оруулалт	2,000,000,000.00	
	Авлага	29,970,477.36	180,722,842.49
	Бараа материал	2,303,871.00	6,505,629.00
	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	3,641,636.27	5,275,000.00
	Бусад эргэлтийн хөрөнгө /ЗГ-ын бонд/		
	Эргэлтийн хөрөнгийн дүн	5,959,461,749.08	6,406,436,023.87
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ		
	Үндсэн хөрөнгө	193,369,979.90	194,741,479.90
	Хуримтлагдсан элэгдэл	(88,359,608.85)	(118,580,262.46)
	Биет бус хөрөнгө	77,712,000.00	77,712,000.00
	Хуримтлагдсан элэгдэл	(16,275,585.10)	(25,771,444.40)
	Хөрөнгө оруулалт ба бусад хөрөнгө		
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	166,446,785.95	128,101,773.04
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	6,125,908,535.03	6,534,537,796.91
Б	ӨР ТӨЛБӨР БА ЦЭВЭР ХӨРӨНГӨ		
1	ӨР ТӨЛБӨР		
	Дансны өглөг	1,500,000.00	
	Цалингийн өглөг	54,750.18	
	Татвар, хураамжийн өглөг		
	Банкны богино хугацаат зээлийн өглөг		
	Урьдчилж орсон орлого		
	Богино хугацаат өглөгийн дүн	1,554,750.18	-
	Урт хугацаат зээл		
	Бусад урт хугацаат өглөг	50,000,000.00	160,000,000.00
	Урт хугацаат өглөгийн дүн	50,000,000.00	160,000,000.00
	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	51,554,750.18	160,000,000.00
2	ЦЭВЭР ХӨРӨНГӨ		
	Нөөц: А.Хязгаарлалтгүй		
	Б.Хязгаарлалттай	5,040,000,000.00	5,040,000,000.00
	Цэвэр хөрөнгийн бусад хэсэг	568,383,765.00	768,400,000.00
	Дахин үнэлгээний нэмэгдэл		
	Хуримтлагдсан үр дүн	465,970,019.85	566,137,796.91
	ЦЭВЭР ХӨРӨНГИЙН ДҮН	6,074,353,784.85	6,374,537,796.91
	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГИЙН ДҮН	6,125,908,535.03	6,534,537,796.91

Гүйцэтгэх захирал:  /П.Чандмань/Нягтлан бодогч:  /Б.Уранбичлэг/Баталгаажуулсан:  ТТГ7028 д.8091099

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

"ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САН"

2016 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО		
	Хүүгийн орлого	757,207,924.20	942,605,833.07
	Төсөл, хөтөлбөрийн орлого	11,806,645.84	3,990,000.00
	Батлан даалтын шимтгэл, хураамжийн орлого	256,564,290.00	218,877,236.00
	Түрээсийн орлого	1,000,000.00	
	Бэлэг, хандив, тусламжийн орлого		
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,026,578,860.04	1,165,473,069.07
2	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ		
	Бэлэг, хандив ба тусламж	-	-
	Байгууллагад өгсөн хандив, тусламж		
	Хувь хүнд өгсөн хандив, тусламж		
	Хандив, тусламж хүргэхтэй холбоотой гарсан зардал		
	Хөтөлбөр хэрэгжүүлсний зардал		
	Төсөл хэрэгжүүлсний зардал	8,986,645.84	3,990,000.00
	Ерөнхий удирдлагын зардал	760,824,683.80	861,627,541.76
	Цалин хөлс, шагнал	383,436,148.06	489,295,508.76
	Нийгмийн даатгалын шимтгэл	42,635,706.77	54,312,768.06
	Засвар үйлчилгээний зардал	4,820,130.00	2,447,250.00
	Түрээсийн зардал	109,523,782.00	151,726,162.00
	Албан томилолтын зардал	27,185,437.20	33,771,095.45
	Тээврийн зардал		
	Элэгдлийн зардал	48,669,071.56	39,716,512.92
	Зар сурталчилгааны зардал	26,977,751.50	14,855,063.20
	Шуудан, холбооны зардал	9,860,602.09	7,200,657.31
	Шатахууны зардал	11,491,216.99	13,108,522.27
	Найдваргүй авлагын зардал		
	Шагнал, урамшууллын зардал	66,680,000.00	28,167,000.00
	Зээлийн хүүгийн зардал		
	Бусад зардал	29,544,837.63	27,027,001.79
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	769,811,329.64	865,617,541.76
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	256,767,530.40	299,855,527.31
3	Үндсэн бус үйл ажиллагааны ашиг, алдагдал	-	328,484.75
	Туслах үйлдвэрлэл, үйлчилгээний ашиг, алдагдал		
	Торгууль, хөнгөлөлтийн ашиг, алдагдал		
	Валютын ханшийн өөрчлөлтийн ашиг, алдагдал		
	Татварын зардал		
	Бусад ашиг, алдагдал		328,484.75
	ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АШИГ, АЛДАГДЛЫН ДҮН	-	328,484.75
	ТАЙЛАНТ ҮЕИЙН ЦЭВЭР ҮР ДҮН	256,767,530.40	300,184,012.06

Гүйцэтгэх захирал: /П.Чандмань/

Нягтлан бодогч: /Б.Уранчимэг/

Баталгаажуулсан:



АУДИТ ХИЙГДСЭН ЦЭВЭР ХӨРӨНГИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

"ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САН"

2016 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар

төгрөг

	ҮЗҮҮЛЭЛТ	Хязгаарлалттай нөөц	Цэвэр хөрөнгийн бусад хэсэг	Хуримтлагдсан үр дүн	Нийт дүн
1	2015 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл		5,460,000,000.00	337,586,254.45	5,797,586,254.45
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	5,000,000,000.00	(5,000,000,000.00)		-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,000,000,000.00	460,000,000.00	337,586,254.45	5,797,586,254.45
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт/бууралт				
5	Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний өсөлт/бууралт	40,000,000.00	108,383,765	(128,383,765.00)	20,000,000.00
6	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц				-
7	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз				-
8	Тайлант үеийн үр дүн			256,767,530.40	256,767,530.40
9	2016 оны 01-р сарын 01-ээрх үлдэгдэл	5,040,000,000.00	568,383,765.00	465,970,019.85	6,074,353,784.85
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
11	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,040,000,000.00	568,383,765.00	465,970,019.85	6,074,353,784.85
12	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				-
13	Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний өсөлт/бууралт		200,016,235	(200,016,235.00)	-
14	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз				-
15	Тайлант үеийн үр дүн			300,184,012.06	300,184,012.06
16	2016 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	5,040,000,000.00	768,400,000.00	566,137,796.91	6,374,537,796.91

Гүйцэтгэх захирал:  /П.Чандмань/Нягтлан бодогч:  /Б.Уранбилэг/Баталгаажуулсан:  5094099

АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

"ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САН"

2016 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар

/төгрөгөөр

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Үйл ажиллагааны мөнгөн орлого	351,809,356.91	349,557,333.57
	Гишүүдийн татвараас орсон мөнгө		
	Төсөл, хөтөлбөрөөс хүлээн авсан мөнгө	11,806,645.84	3,860,000.00
	Бэлэг, хандив, тусламж		
	Түрээсийн орлогод хүлээн авсан мөнгө	1,000,000.00	
	Бусад орлого	339,002,711.07	345,697,333.57
1.2	Үйл ажиллагааны мөнгөн зарлага	747,329,944.04	868,535,203.56
	Ажиллагчдад олгосон мөнгө	356,404,403.17	425,267,364.65
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	80,237,050.56	100,866,891.56
	Бараа материал худалдан авахад төлсөн мөнгө	11,135,389.00	18,138,340.00
	Ашиглалтын зардалд төлсөн мөнгө	123,507,524.09	156,283,585.31
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө	12,303,437.00	11,609,200.00
	Бэлтгэн нийлүүлэгчдэд төлсөн бусад мөнгө	127,207,551.27	113,338,891.27
	Төлсөн хүү		
	Төлсөн татвар	34,134,588.95	43,030,930.75
	Даатгалын төлбөрт төлсөн мөнгө		
	Бусад	2,400,000.00	
	Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(395,520,587.13)	(518,977,870.01)
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
	Худалдсан урт хугацаат хөрөнгийн орлого		2,000,000,000.00
	Худалдаж авсан урт хугацаат хөрөнгө	(17,184,490.00)	(1,371,500.00)
	Худалдсан хөрөнгө оруулалтын орлого		
	Худалдаж авсан хөрөнгө оруулалт	(2,000,000,000.00)	
	Бусад		
	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(2,017,184,490.00)	1,998,628,500.00
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
	Банкнаас авсан зээл		
	Санхүүгийн түрээсийн өглөгийн төлбөр		
	Зээлийн төлөлт		
	Улсаас өгсөн санхүүжилт	20,000,000.00	
	Урт хугацаат өрийн тайлангийн хугацааны төлөлт		
	Хүү ба урамшууллын орлого	1,355,972,793.16	810,736,157.94
	Валютын ханшийн зөрүү		
	Бусад		
	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	1,375,972,793.16	810,736,157.94
	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(1,036,732,283.97)	2,290,386,787.93
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	4,960,278,048.42	3,923,545,764.45
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,923,545,764.45	6,213,932,552.38

Гүйцэтгэх захирал:/П.Чандмань/

Нягтлан бодогч:/Б.Уранбилэг/

Баталгаажуулсан:
